



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 440

Номгон

“Цагаан сар”-ын баярыг тохиолдуулан
үзэсгэлэн худалдаа зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 14.2, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 156 дугаар тогтоол “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийн 4.5.4 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 9/58 дугаар “Аймгийн 2026 оны хөгжлийн төлөвлөгөөг батлах тухай” тогтоолын 90 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн бичил, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлэх, зах зээлд таниулан сурталчлах, хэрэглэгч захиалагчтай холбох зорилгоор Монгол үндэстний уламжлалт Цагаан сарын баярыг тохиолдуулан үзэсгэлэн худалдааг 2026 оны 02 дугаар сарын 06-08-ны өдрүүдэд Биеийн тамир спортын газрын зааланд зохион байгуулсугай.

2.Үзэсгэлэн худалдааг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, зохион байгуулах ажлын удирдамжийг хоёрдугаар, шаардагдах зардлын тооцоог гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Үзэсгэлэн худалдаа зохион байгуулахад шаардагдах 5 000 000 (Таван сая) төгрөгийг Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлж “Хонгорын эрхэт зангилаа бичил жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн холбоо”-нд шилжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Отгонбаяр)-д зөвшөөрсүгэй.


4.Үзэсгэлэн худалдааг иргэдэд хүртээмжтэй, оролцогчдын борлуулалтын орлогыг нэмэгдүүлэн, үнийн хөөрөгдөлгүй зохион байгуулж үр дүнг 2026 оны 02 дугаар сарын 13-ны дотор тайлагнахыг Ажлын хэсэг (Г.Энхбаяр), “Хонгорын эрхэт

зангилаа бичил жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн холбоо"-нд тус тус үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Орлогч (Б.Наранбаяр)-д даалгасугай.

ДАРГА  ЗЭНХБАТ

Аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр
сарын 01-ны өдрийн 1/10 дүгээр
захирамжийн 01 дүгээр хавсралт



ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДАА ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч:

Г.Энхбаяр

Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт бодлого
төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч

Гишүүдэд

Т.Цэвээндорж

Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын дарга,
хошууч

М.Шагдарсүрэн

Стандарт хэмжил зүйн хэлтсийн дарга

М.Эрхэмбаяр

Хүнс хөдөө аж ахуйн газрын даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч

Б.Хүрэлчулуун

Биеийн тамир спортын газрын даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч

Б.Дэлгэрдалай

“Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци”
ХХК-ийн захирал

Л.Ганбаяр

Мал эмнэлгийн газрын Хяналтын улсын байцаагч

Б.Анухатан

Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн, Шударга
өрсөлдөөн хэрэглэгчийн төлөөх газрын
хэрэглэгчийн эрхийг хамгаалах улсын байцаагч

Б.Алтансүх


Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын
мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга

Д.Уранчимэг

“Хонгорын эрхэт зангилаа бичил жижиг дунд
үйлдвэрлэл эрхлэгчдийн холбоо”-ны дарга

Аймгийн Засаг даргын 022-оны 01 дүгээр
сарын 22-ны өдрийн 44.0 дүгээр
захирамжийн 01 дүгээр хавсралт



ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДАА ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч:

Г.Энхбаяр

Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт бодлого
төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч

Гишүүдэд

Т.Цэвээндорж

Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын дарга,
цагдаагийн дэд хурандаа

М.Шагдарсүрэн

Стандарт хэмжил зүйн хэлтсийн дарга

М.Эрхэмбаяр

Хүнс хөдөө аж ахуйн газрын даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч

Б.Хүрэлчулуун

Биеийн тамир спортын газрын даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч

Б.Дэлгэрдалай

“Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци”
ХХК-ийн захирал

Л.Ганбаяр

Мал эмнэлгийн газрын Хяналтын улсын байцаагч

Б.Анухатан

Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн, Шударга
өрсөлдөөн хэрэглэгчийн төлөөх газрын
хэрэглэгчийн эрхийг хамгаалах улсын байцаагч

Б.Алтансүх

Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын
мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга

Д.Уранчимэг

“Хонгорын эрхэт зангилаа бичил жижиг дунд
үйлдвэрлэл эрхлэгчдийн холбоо”-ны дарга

Аймгийн Засаг даргын 2026 оны 01 дүгээр
сарын 08-ны өдрийн 4/10 дүгээр
захирамжийн 02 дугаар хавсралт



ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДААНЫ УДИРДАМЖ

Зорилго: Орон нутгийн бичил, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулалтыг нэмэгдүүлэх, хэрэглэгч захиалагчтай холбох, харилцан туршлага солилцоход оршино.

Нэг: Хамрах хүрээ, хугацаа

Баянхонгор аймгийн 20 сумын бичил, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид, бүлэг, нөхөрлөл, хоршоо, аж ахуйн нэгжүүд хамрагдана.

2026 оны 02 дугаар сарын 06-08-ны өдрүүдэд аймгийн Биеийн тамирын спортын газрын зааланд зохион байгуулагдана.

Хоёр: Үзэсгэлэн худалдаанд оролцуулах бүтээгдэхүүн

1. Хүнсний бүтээгдэхүүн
2. Хөнгөн үйлдвэрлэл
3. Гар урлал, зураг, эдлэл хэрэгсэл
4. Мал аж ахуй, малын гаралтай бүтээгдэхүүн
5. Бусад

Гурав. Шилдэг бүтээгдэхүүн шалгаруулалт

- Шилдэг өрхийн үйлдвэрлэгч
- Шилдэг залуу үйлдвэрлэгч
- Шилдэг хоршоологч
- Шилдэг хүнс үйлдвэрлэгч
- Шилдэг хөнгөн үйлдвэр эрхлэгч тус тус шалгаруулж өргөмжлөл, мөнгөн шагнал гардуулна.

Дөрөв. Зохион байгуулалт

Ерөнхий зохион байгуулагчид:

- Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газар
- "Хонгорын эрхэт зангилаа бичил жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн холбоо"

Хамтран зохион байгуулагчид

- Хүнс хөдөө аж ахуйн газар
- Биеийн тамир спортын газар
- Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК

Тав. Бусад

- Үзэсгэлэн худалдааны мэдээллийг Сумдын ЗДТГ, Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтнүүд хариуцан сумынхаа иргэн, ААН-д хүргэх, оролцуулах

- Овор ихтэй болон хөлдүү бүтээгдэхүүнийг гадаа талбайд байрлуулсан асар майханд худалдаална.

- Оролцогчид сав баглаа боодлын шаардлага хангасан, орон нутагт үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн худалдан борлуулах ба сүлжээний бараа бүтээгдэхүүн, экспортын бараа бүтээгдэхүүн худалдан борлуулахгүй.

- Оролцогчид үнэ өсгөж, үнийн хөөргөдөл үүсгэхгүй байх

- Малын гаралтай бүтээгдэхүүний гарал үүслийн бичиг, шинжилгээний бичгийг үзүүлж мандат авах, үзэсгэлэн худалдааны үеэр биедээ авч хүнсний улсын хяналтын байцаагч, ажлын хэсэгт шалгуулах

Зургаа. Үзэсгэлэн худалдааны хөтөлбөр

Хугацаа	Үйл ажиллагаа	Хариуцах эзэн
1	2	3
2026 оны 02 дугаар сарын 05-ны өдөр		
14:00-18:00	Бэлтгэл ажил хангах, оролцогчдыг бүртгэх, хуваарилах, байршуулах ширээ	-Баянхонгор сумын ЗДТГ газар Б.Алтансүх -Хүнс, хөдөө аж ахуйн газар Б.Мөнхтогтох, Б.Оюунцэцэг, С.Сайнхүү, Г.Саранзаяа, -Стандарт хэмжил зүйн хэлтсийн мэргэжилтэн С.Амаржаргал, - Хонгорын эрхэт зангилаа бичил жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн холбоо
2025 оны 02 дугаар сарын 06-ны өдөр		
09:00-12:00	Үзэсгэлэн худалдаанд оролцогчдыг бүртгэх, бараа бүтээгдэхүүнийг байршуулах	Ажлын хэсэг
12:20-13:00	Үзэсгэлэн худалдааг нээж аймгийн Засаг дарга Э.Энхбат үг хэлнэ	-БОНХОХБТХ-ийн дарга Г.Энхбаяр -Хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Эрхэмбаяр, -Стандарт хэмжил зүйн хэлтсийн дарга М.Шагдарсүрэн -Биеийн тамир спортын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч У.Хүрэлчулуун - Хонгорын эрхэт зангилаа бичил жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн холбоо
09:00-19:00	Үзэсгэлэн худалдаа зохион байгуулна	Ажлын хэсэг
2025 оны 02 дугаар сарын 07-08-ны өдөр		
09:00-19:00	Үзэсгэлэн худалдаа зохион байгуулна. (Үзэсгэлэн худалдаанд оролцогчдод ХАА-н үйлчилгээний талаар мэдээлэл хийх, боршур тараах, орлогын судалгаа авах, бараа бүтээгдэхүүнээс дээж авах, ТВ-ын сурвалжилга	Ажлын хэсэг

1	2	3
	хийгдэж оролцогчдын бараа бүтээгдэхүүнийг сурталчлах)	
15:00-16:00	Үзэсгэлэн худалдаанд орлогчдод Батламж хадгалуулах	Ажлын хэсэг
16:00-19:00	Үзэсгэлэн худалдааг хаах, заал хүлээлгэн өгөх	Ажлын хэсэг

_____оОо_____

Аймгийн Засаг даргын 01 дүгээр
сарын 28-ны өдрийн 11 дүгээр
захирамжийн 03 дугаар хавсралт

ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДААНЫ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж бүрийн үнэ	Бүгд үнэ	Төсөв хариуцах байгууллага
1	2	3	4	5	6	7
1	5x4 аннос /дотор зүүх/	ш	1	19000	380.000	Хонгорын эрхэт зангилаа бичил жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн холбоо
2	Гадна зам дагуу байршуулах, спорт хорооны гадна байршуулах хаяг 5x3	ш	1	19000	285.000	Хонгорын эрхэт зангилаа бичил жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн холбоо
3	Жижиг хаягжуулалт	ш	10	25000	250.000	Хонгорын эрхэт зангилаа бичил жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн холбоо
4	Нээлтийн номер	ш	1	-	-	Хүнс, хөдөө аж ахуйн газар
5	Заалны цэвэрлэгээ, хог ачилт	ш	6	25000	150.000	Хонгорын эрхэт зангилаа бичил жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн холбоо
6	Шагнал	ш	5	200000	1.000.000	Ажлын хэсэг
7	Хэвлэл зар сурталчилгаа /лайв/	ш	1	300000	300.000	Хонгорын эрхэт зангилаа бичил жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн холбоо
8	Ширээ, дэвсгэр, хаяг зөөх, ачих	ш	2	100000	200.000	Хонгорын эрхэт зангилаа бичил жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн холбоо
9	Зар сурталчилгаа /төв замын лед дэлгэцээр цацах/	ш	3	30.000	90.000	Хонгорын эрхэт зангилаа бичил жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн холбоо
10	Дотор хаяг зүүх торосон утас	м	300	3000	900.000	Хонгорын эрхэт зангилаа бичил жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн холбоо
11	Подкост, рил бичлэг	удаа	3	100.000	300.000	Хонгорын эрхэт зангилаа бичил жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн холбоо
12	Оролцогчдын мандат	ш	120	3.500	420.000	Хонгорын эрхэт зангилаа бичил жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн холбоо
13	Заалны тохижилт				725.000	Хонгорын эрхэт зангилаа бичил жижиг дунд

1	2	3	4	5	6	7
						үйлдвэрлэл эрхлэгчдийн холбоо
Нийт					5.000.000	

---oOo---



حکومت اسلامیہ پاکستان
وزارت تعلیم و تربیت

$$\frac{2}{0}$$

Summary

५५

R ③

सुख

R
O
R
G

9/6

“ සමහරුන්ට - සමහරුන්ට - සමහරුන්ට ”

אברהם ויצחק

മുഖം

[illegible][illegible]

۵. محاسبه و پرداخت هزینه های مربوط به ...

[illegible]

[illegible][illegible]

..

A red rectangular stamp with Persian text, crossed out with a large black 'X'. The text is arranged in a grid-like pattern, with some words appearing vertically and others horizontally. The stamp is located in the center of the page, overlapping the signature and the date.